



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
ЖИНСТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2022 оны 04 сарын 22 өдөр

Дугаар А/42

Бодь

Техникийн хяналтын үзлэг, тээврийн хэрэгслийн албан татвар хураалтын ажлыг зохион байгуулах тухай

Авто тээврийн тухай хуулийн 7.1.1 дэх заалт, аймгийн Засаг Даргын 2022 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн А/173 захирамжийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тээврийн хэрэгслийн техникийн хяналтын 2022 оны үзлэг тооллогын ажлын хэсгийг хавсралтаар баталсугай.


2.Орон нутагт техникийн хяналтын үзлэгийг явуулах үеэр Эрүүл мэндийн төв, Цагдаагийн хэсэг, сумын Онцгой комисс бусад төрийн байгууллагын оролцоотойгоор хүн дунд коронавирусын халдвар тархахаас урьдчилан сэргийлэх бүхий л арга хэмжээ авч, үйлчилгээний газруудад бөөгнөрөл үүсгэхгүй байхаар зохион байгуулж, үйлчилгээ төлбөр тооцооны цахим хэлбэрийг нэн түрүүнд ашиглах, түргэн шуурхай үйлчилгээ үзүүлэхэд хяналт тавьж ажиллахыг ажлын хэсгийн бүрэлдэхүүнд даалгасугай.

3.Тус суманд бүртгэлтэй байгаа Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар, агаар бохирдлын төлбөр, орон нутгийн авто зам ашигласны төлбөр, хураамжийг холбогдох хууль тогтоомжийн дагуу хураан авч төсөвт төвлөрүүлэхийг Татварын улсын байцаагч (Г.Оюунсүрэн)-д үүрэг болгосугай.

4. Техникийн хяналтын үзлэг, тээврийн хэрэгслийн албан татвар хураалтын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Н.Сумъяа)-д үүрэг болгосугай.


ДАРГА

Р.БАТЖАРГАЛ



642201067

Сумын Засаг даргын 2022 оны 04 дүгээр
сарын 22 -ны өдрийн 142 тоот
захирамжийн хавсралт



Ажлын хэсгийн бүрэлдэхүүн

Ажлын хэсгийн ахлагч

Н.Сумъяа

(Засаг даргын орлогч)

Гишүүд

М.Цэнд-Аюуш

(Хэсгийн төлөөлөгч)

Ц.Цэрэнхүү

(Эрүүл мэндийн төвийн дарга)

Т.Цэнд-Аюуш

(Соёл, спортын төвийн дарга)

Г.Оюунсүрэн

(Татварын Улсын байцаагч)

Б.Ганцэцэг

(5 дугаар багийн Засаг дарга)

Э.Даваацэрэн

(Хэсгийн цагдаа)

_____ оОо _____